


**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2015 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

“Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны өөрчлөлт, шинэчлэлтийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн санаачилсан “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтын тухай” хуулийн төсөл, түүнийг даган нэмэлт, өөрчлөлт орох хуулиудын төсөлд санал боловсруулах ажлын хэсэг, зөвлөх багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсэг, зөвлөх багийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтын тухай” хуулийн төсөл, түүнийг даган нэмэлт, өөрчлөлт орох хуулиудын төслийн саналыг эрүүл мэндийн салбарын бодлоготой уялдуулан боловсруулан, хуулийг санаачилсан Монгол Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдтэй хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтэн, бусад хүмүүсийг татан оролцуулах, сайдыг мэдээллээр тогтмол хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Р.Оюунханд)-т үүрэг болгосугай.
3. Ажлын хэсгийг хэрэгцээт тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны газар, хэлтсийн дарга, харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

080388

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03... сарын 27.-ны
өдрийн 15..тоот тушаалтын
нэгдүгээр хавсралт

**“Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтын тухай”
хуулийн төсөл, түүнийг даган нэмэлт, өөрчлөлт орох хуулиудын
төсөлд санал боловсруулах ажлын хэсэг, зөвлөх багийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн ахлагч: Р.Оюунханд

Стратегийн бодлого
төлөвлөлтийн газрын даргын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Гишүүд: О.Баяр

Эрүүл мэндийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Э.Оюунсүрэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын даргын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Н.Бат-Эрдэнэ

Төрийн захиргааны удирдлагын
газрын Хууль эрх зүйн албаны
дарга

Б.Энхцэцэг

Стратегийн бодлого
төлөвлөлтийн газрын
мэргэжилтэн

С.Гончигсумлаа


Стратегийн бодлого
төлөвлөлтийн газрын
мэргэжилтэн

Г.Баясгалан

Улсын II төв эмнэлгийн ерөнхий
захирал

А.Болд

Азийн хөгжлийн банкны “Эрүүл
мэндийн салбарын хөгжил
хөтөлбөр-4”, “Эрүүл мэндийн
салбарын хөгжил хөтөлбөр-5”
төслийн удирдагчийн үүргийг
түр орлон гүйцэтгэгч



Н.Одонгуа

Анагаахын шинжлэх ухааны
үндэсний их сургуулийн
Сувилахуйн салбар сургуулийн
захирал (зөвшилцсэнөөр)

Ажлын хэсгийн нарийн
бичгийн дарга:

С.Эрдэнэтуюяа

Стратегийн бодлого
төлөвлөлтийн газрын
мэргэжилтэн

П.Оюунцэцэг

Эрүүл мэндийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын Нийгмийн эрүүл
мэндийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Зөвлөх багийн гишүүд: П.Нямдаваа

Шинжлэх ухааны академи,
Монголын Анагаах ухааны
академийн гишүүн, Академич,
Анагаахын шинжлэх ухааны
доктор, профессор
(зөвшилцсэнөөр)

С.Сонин

Өрхийн анагаах ухааны
мэргэжилтнүүдийн холбооны
ерөнхийлөгч (зөвшилцсэнөөр)

Ж.Алтантуяа

Азийн хөгжлийн банкны Монгол
дах суурин төлөөлөгчийн
газрын нийгмийн салбарын
асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн (зөвшилцсэнөөр)

Л. Төмөрбаатар

Хавдар судлалын үндэсний
төвийн ерөнхий захирал

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03... сарын 27.-ны
өдрийн 115... тоот тушаалтын
хоёрдугаар хавсралт

“Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтын тухай”
хуулийн төсөл, түүнийг даган нэмэлт, өөрчлөлт орох хуулиудын
төсөлд санал боловсруулах ажлын хэсэг, зөвлөх багийн ажлын
удирдамж

1. Үндэслэл:

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтын тухай” хуулийн төсөл, түүнийг даган нэмэлт, өөрчлөлт орох хуулиудын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн бариад байгаа бөгөөд энэхүү хуулийн төсөл болон дагалдан нэмэлт, өөрчлөлт орох хуулиудын төслийг эрүүл мэндийн салбарын бодлоготой уялдуулах шаардлагатай байна.


2. Зорилго:

Эрүүл мэндийн байгууллагын засаглал, санхүүжилтийг боловсронгуй болгох, өрх, сумын Эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусlamж үйлчилгээг өргөжүүлж, төрөлжсөн мэргэжлийн тусlamж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн ачааллыг бууруулах, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн болон төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа, нийгмийн баталгаа, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл зэрэг асуудлаарх эрүүл мэндийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хууль санаачлагчидтай хамтран ажиллах

3. Үйл ажиллагааны чиглэл:

- Хууль санаачлагч УИХ-ын гишүүдтэй дараах хуулиуд дээр хамтран ажиллана. Үүнд:
 - “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтын тухай” хуулийн төсөлд санал боловсруулах
 - “Эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулах
 - “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулах
 - “Төрийн албаны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулах
 - “Тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулах
 - “Төсвийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулах

- Дагалдан нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулиудын төсөлд санал боловсруулах
- Ажлын хэсгийн ажлын явцын талаар холбогдох эрх бүхий албан тушаалтнуудыг мэдээллээр ханганд ажиллана.
- Зөвлөх багийн гишүүд ажлын хэсгийн гишүүдийн боловсруулсан саналд зөвлөгөө өгөх, хууль санаачлагчдад төрийн захиргааны төв байгууллагаас баримталж байгаа бодлого, хуулийн төсөлд боловсруулсан саналыг тайлбарлан ойлгуулахад дэмжлэг үзүүлэх



4. Хүрэх үр дүн:

“Эмнэлгийн тусламж үйлчилгээний зохион байгуулалтын тухай”, “Эрүүл мэндийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Тэмдэгтийн хураамжийн тухай”, “Төсвийн тухай” зэрэг холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт орж, эрүүл мэндийн салбарын бодлогод нийцсэн хууль эрх зүйн орчин бүрдэнэ.